



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Орхон сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/214-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2024 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитын гүйцэтгэсэн: Мэдээлэл Аудит ХХК-ийн Сэлэнгэ салбар Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт..	11-12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
4. Аудитын тайлан.....	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17-19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	20-21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
ЗГ	Засгийн газар
БЕГ	Боловсролын ерөнхий газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БҮХТ	Боловсролын үнэлгээний хөгжлийн төв



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ОРХОН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.СОЁЛМАА ТАНАА

2024.02.23 № СЭА-2024/214-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Орхон сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд аймгийн БШУГ-аас 1,822.1 мянган төгрөгийн сурах бичиг, 2,832.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Дэлхийн зөн ОУБ-аас 1,413.1 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж, сургуулийн 70 жилийн ойн хүрээнд Улаанбаатар гурил ХХК-аас 39,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, төгсөгчдийн хандив тусламжаар 45,034.8 мянган төгрөгийн барилгын засвар болон гадна талбайн тохижилт хийгдэн капиталжуулж, 10,917.5 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна.

Орхон сумын Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/324 дүгээр тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 2 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 19,689.0 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус сургууль нь 2023 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 11 зорилтын хүрээнд 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 95.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	170,423,807.62	266,184,351.62
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	48,344,247.49	120,407,429.75
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	48,344,247.49	120,407,429.75
31210	Төгрөг	48,344,247.49	120,407,429.75
31211	Төрийн сангийн харилцах	48,344,247.49	120,407,429.75
35	БАРАА МАТЕРИАЛ	122,079,560.13	145,776,921.87
35400	Хангамжийн материал	122,079,560.13	145,776,921.87
35420	Аж ахуйн материал	56,966,660.84	56,966,660.84
35470	Бусад хангамжийн материал	65,112,899.29	88,810,261.03
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,738,062,266.10	1,753,605,382.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,738,062,266.10	1,753,605,382.90
39200	Биет хөрөнгө	1,720,485,641.21	1,736,341,258.05
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,001,399,952.59	2,037,329,972.59
39202	Хуримтлагдсан элэгдэл	(530,363,679.88)	(571,868,795.53)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,562,500.00	53,562,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(14,562,500.00)	(15,537,500.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	255,216,511.16	276,064,706.16
39206	Хуримтлагдсан элэгдэл	(102,876,686.90)	(165,161,613.83)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	102,672,949.19	123,295,359.19
39208	Хуримтлагдсан элэгдэл	(39,115,241.87)	(53,139,113.81)
39214	Бусад үндсэн хөрөнгө	42,489,440.00	64,464,240.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(20,621,132.79)	(24,974,158.93)
39217	Ном	11,683,529.71	12,305,662.21
39300	Биет бус хөрөнгө	17,576,624.89	17,264,124.85
39301	Програм хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,109,375.11)	(1,421,875.15)
39303	Бусад биет бус хөрөнгө	17,186,000.00	17,186,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,908,486,073.72	2,019,789,734.52
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,908,486,073.72	2,019,789,734.52
51	Засгийн газрын хувь оролцоо	1,908,486,073.72	2,019,789,734.52
51100	Засгийн газрын оруулсан капитал	300,889,131.20	300,889,131.20
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	300,889,131.20	300,889,131.20
51200	Хуримтлагдсан үр дүн	1,578,056,447.52	1,689,360,108.32
51210	Өмнөх үеийн үр дүн	(353,486,627.84)	1,578,056,447.52
51220	Тайлант үеийн үр дүн	1,931,543,075.36	111,303,660.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	29,540,495.00	29,540,495.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,908,486,073.72	2,019,789,734.52

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,948,616,472.53	1,281,832,046.73
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,954,006,012.62	134,240,911.40
120	Нийтлэг татварын бус орлого	1,954,006,012.62	134,240,911.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,473,400.00	9,319,608.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,473,400.00	2,949,608.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	6,370,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,821,370,101.49	101,020,057.50
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	131,162,511.13	23,901,245.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	994,610,459.91	1,147,591,135.33
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	732,221,300.00	911,241,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	732,221,300.00	911,241,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	500,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	261,889,159.91	236,349,635.33
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	261,889,159.91	236,349,635.33
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,017,073,397.17	1,170,528,385.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,017,073,397.17	1,170,528,385.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	967,943,365.17	1,129,732,985.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	503,441,857.00	618,984,528.00
210101	Үндсэн цалин	374,941,252.00	432,802,141.00
210102	Нэмэгдэл	106,485,392.00	156,019,576.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,015,213.00	-
210104	Урамшуулал	-	30,162,811.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,590,762.51	78,298,360.01
210201	Тэтгэврийн даатгал	44,987,563.94	53,986,736.80
210202	Тэтгэмжийн даатгал	5,098,406.34	6,183,285.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,031,684.90	4,938,678.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,459,798.31	1,194,899.21
210205	Эрүүл мэндийн даатгал	9,013,309.02	11,994,761.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	202,473,114.27	222,206,135.33
210301	Гэрэл, цахилгаан	11,369,354.77	11,938,767.07
210302	Түлш, халаалт	190,714,759.50	209,827,368.26
210303	Цэвэр, бохир ус	389,000.00	440,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,717,560.00	-
210401	Бичиг хэрэг	4,626,290.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,068,500.00	-
210408	Бараа материал актальсны зардал	2,022,770.00	-
2105	Нормативт зардал	46,676,546.00	51,503,806.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	704,166.00	-
210502	Хоол, хүнс	45,972,380.00	51,503,806.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,208,825.00	1,273,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	123,625.00	-
210604	Урсгал засвар	2,085,200.00	1,273,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,007,900.00	5,284,709.73
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,473,400.00	1,369,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,534,500.00	3,915,209.73
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	134,826,800.39	152,181,946.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,395,650.00	21,215,606.16
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,103,315.00	7,511,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	110,327,835.39	123,454,440.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,130,032.00	40,795,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,130,032.00	40,795,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30,158,932.00	27,997,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,971,100.00	12,797,900.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,931,543,075.36	111,303,660.80
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,931,543,075.36	111,303,660.80

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	996,083,859.91	1,156,910,743.33
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,473,400.00	9,319,608.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,473,400.00	9,319,608.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,473,400.00	9,319,608.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,473,400.00	2,949,608.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	6,370,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	994,610,459.91	1,147,591,135.33
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	732,221,300.00	911,241,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	732,221,300.00	911,241,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	500,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	261,889,159.91	236,349,635.33
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	261,889,159.91	236,349,635.33
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	920,719,612.42	1,046,870,061.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	920,719,612.42	1,046,870,061.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	871,686,080.42	1,006,074,661.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	505,073,246.00	618,984,528.00
210101	Үндсэн цалин	376,964,513.00	432,802,141.00
210102	Нэмэгдэл	106,093,520.00	156,019,576.00
210104	Урамшуулал	22,015,213.00	30,162,811.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,959,373.51	78,298,360.01
210201	Тэтгэврийн даатгал	43,485,818.40	53,986,736.80
210202	Тэтгэмжийн даатгал	5,098,406.34	6,183,285.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,031,684.90	4,938,678.00
210204	Ажилгүйдлийн даатгал	938,282.85	1,194,899.21
210205	Эрүүл мэндийн даатгал	9,405,181.02	11,994,761.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	225,530,115.91	222,206,135.33
210301	Гэрэл, цахилгаан	11,369,354.77	11,938,767.07
210302	Түлш, халаалт	213,771,761.14	209,827,368.26
210303	Цэвэр, бохир ус	389,000.00	440,000.00
2105	Нормативт зардал	45,960,380.00	51,503,806.00
210502	Хоол, хүнс	45,960,380.00	51,503,806.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	386,850.00	1,273,500.00
210604	Урсгал засвар	386,850.00	1,273,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,007,900.00	5,284,709.73
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,473,400.00	1,369,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,534,500.00	3,915,209.73
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,768,215.00	28,523,622.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,664,900.00	21,011,722.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,103,315.00	7,511,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,033,532.00	40,795,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,033,532.00	40,795,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30,062,432.00	27,997,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,971,100.00	12,797,900.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	75,364,247.49	110,040,682.26
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	27,020,000.00	37,977,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27,020,000.00	37,977,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	27,020,000.00	37,977,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	27,020,000.00	37,977,500.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(27,020,000.00)	(37,977,500.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	48,344,247.49	72,063,182.26
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	48,344,247.49
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	48,344,247.49	120,407,429.75

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	300,889,131.20	29,540,495.00	(353,486,627.84)	(23,057,001.64)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	300,889,131.20	29,540,495.00	(353,486,627.84)	(23,057,001.64)
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	1,931,543,075.36	1,931,543,075.36
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	300,889,131.20	29,540,495.00	1,578,056,447.52	1,908,486,073.72
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	300,889,131.20	29,540,495.00	1,578,056,447.52	1,908,486,073.72
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	300,889,131.20	29,540,495.00	1,578,056,447.52	1,908,486,073.72
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	111,303,660.80	111,303,660.80
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	300,889,131.20	29,540,495.00	1,689,360,108.32	2,019,789,734.52

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэлийн зөрүү/хэтрэлт, хэмнэлт/	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,204,078,700.00	1,084,847,561.07	119,231,138.93	90.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,204,078,700.00	1,084,847,561.07	119,231,138.93	90.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,156,525,500.00	1,044,052,161.07	112,473,338.93	90.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	709,330,700.00	618,984,528.00	90,346,172.00	87.3
210101	Үндсэн цалин	482,584,900.00	432,802,141.00	49,782,759.00	89.7
210102	Нэмэгдэл	191,587,800.00	156,019,576.00	35,568,224.00	81.4
210104	Урамшуулал	35,158,000.00	30,162,811.00	4,995,189.00	85.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,666,400.00	78,298,360.01	10,368,039.99	88.3
210201	Тэтгэврийн даатгал	60,293,300.00	53,986,736.80	6,306,563.20	89.5
210202	Тэтгэмжийн даатгал	7,093,200.00	6,183,285.00	909,915.00	87.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,674,700.00	4,938,678.00	736,022.00	87.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,418,600.00	1,194,899.21	223,700.79	84.2
210205	Эрүүл мэндийн даатгал	14,186,600.00	11,994,761.00	2,191,839.00	84.5
2103	Байр мшиглалттай холбоотой тогтмол зардал	225,818,700.00	222,206,135.33	3,612,564.67	98.4
210301	Гэрэл, цахилгаан	15,000,000.00	11,938,767.07	3,061,232.93	79.6
210302	Түлш, халаалт	209,900,000.00	209,827,368.26	72,631.74	100.0
210303	Цэвэр, бохир ус	918,700.00	440,000.00	478,700.00	47.9
2105	Нормативт зардал	56,197,600.00	51,503,806.00	4,693,794.00	91.6
210502	Хоол, хүнс	56,197,600.00	51,503,806.00	4,693,794.00	91.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,353,300.00	14,143,500.00	209,800.00	98.5
210604	Урсгал засвар	14,353,300.00	14,143,500.00	209,800.00	98.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,572,700.00	5,284,709.73	2,287,990.27	69.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,650,400.00	1,369,500.00	1,280,900.00	51.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,922,300.00	3,915,209.73	1,007,090.27	79.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,586,100.00	53,631,122.00	954,978.00	98.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,052,000.00	46,119,222.00	932,778.00	98.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,534,100.00	7,511,900.00	22,200.00	99.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,553,200.00	40,795,400.00	6,757,800.00	85.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	47,553,200.00	40,795,400.00	6,757,800.00	85.8
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	34,755,300.00	27,997,500.00	6,757,800.00	80.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,797,900.00	12,797,900.00	-	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,204,078,700.00	1,156,910,743.33	47,167,956.67	96.1
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	911,241,500.00	911,241,500.00	-	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	911,241,500.00	911,241,500.00	-	100.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	240,172,000.00	236,349,635.33	3,822,364.67	98.4
320001	Орон нутгийн төсвөөс	240,172,000.00	236,349,635.33	3,822,364.67	98.4
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	52,665,200.00	9,319,608.00	43,345,592.00	17.7
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,650,400.00	2,949,608.00	(299,208.00)	111.3
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,685,100.00	6,370,000.00	(4,684,900.00)	378.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	48,329,700.00	-	48,329,700.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	48,344,247.49	(48,344,247.49)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	120,407,429.75	(120,407,429.75)	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Орхон сумын ерөнхий боловсролын сургууль нь “Хамтын оролцоо, үнэлгээний үр дүнд суурилсан менежментийг сайжруулж, хүүхэд бүрийн онцлогт нийцүүлэн сурах, хөгжих арга барилыг нэвтрүүлэн сургалтын үйл ажиллагааг чанар, үр дүнтэй зохион байгуулах” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхэд бүрийн онцлог, ялгаатай байдал, явцын үнэлгээнд суурилан сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг үргэлжлүүлэн үр дүнтэй хэрэгжүүлж, сурлагын амжилтад ахиц гаргах,
- Онцгой байдлын үед суралцагч өөрийгөө болон бусдыг хамгаалах мэдлэг, ур чадвараа хэрэгжүүлэх дадлага, сургуулилтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж, аливаа гамшгийн эрсдэлийг даван туулах чадварыг хөгжүүлэх,
- Сурч хөгжих тэгш, айдасгүй, амар тайван орчин бүрдүүлж, ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэн, эерэг хандлага, соёлыг төлөвшүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Боловсролын ерөнхий хууль 2023 оны 7 дугаар сарын 7-нд батлагдсан,*
- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт,*
- *БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 дүгээр албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд 1."ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх", 2."Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом,наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх,худалдан авах ажиллагааг зохион байгуулах" чиглэлийг хүргүүлсэн гэх мэт,*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Орхон сумын ерөнхий боловсролын сургууль нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Орхон сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 111,303.7 мянган төгрөгөөр буюу 6.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	48,344.2	120,407.4	72,063.2
Авллага	-	-	-
Бараа материал	122,079.5	145,776.9	23,697.4
Үндсэн хөрөнгө	1,738,062.3	1,753,605.4	15,543.1
Нийт хөрөнгө	1,908,486.0	2,019,789.7	111,303.7
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,908,486.0	2,019,789.7	111,303.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,908,486.0	2,019,789.7	111,303.7

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 120,407.4 мянган төгрөг болж 72,063.2 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлтийг Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх “Энэ хуулийн 7.7 дахь хэсэг эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
2. Бараа материалын дансны үлдэгдэл 145,776.9 мянган төгрөг болж 23,697.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 96,740.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, БШУЯ-наас 3,122.2 мянган төгрөгийн сурах бичиг, Дэлхийн зөн ОУБ-аас 1,920.9 мянган төгрөгийн хичээлийн хэрэгсэл, хангамжийн материал, төгсөгчдийн хандиваар 3,801.6 мянган төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйл, аймгийн БШУГ-аас 15,056.6 мянган төгрөгийн сурах бичиг, туршилтын хичээлийн иж бүрдэл, хэрэглэгдэхүүн үнэ төлбөргүйгээр хүлээн авч, үйл ажиллагаанд 96,944.8 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулснаас,
3. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,753,605.4 мянган төгрөг болж 15,543.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 37,977.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, аймгийн БШУГ-аас 1,822.1 мянган төгрөгийн сурах бичиг, 2,832.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Дэлхийн зөн ОУБ-аас 1,413.1 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж, сургуулийн 70 жилийн ойн хүрээнд Улаанбаатар гурил ХХК-аас 39,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, төгсөгчдийн хандив тусламжаар 45,034.8 мянган төгрөгийн барилгын засвар болон гадна талбайн тохижилт хийгдэн капиталжуулж, 10,917.5 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр хүлээн авснаас тус тус шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 896,250.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 242,271.8 мянган төгрөг нийт 1,138,521.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс улсын төсвийн санхүүжилтийг 170,494.2 мянган төгрөгөөр бууруулж 725,755.8 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 20,000.0 мянган төгрөгөөр бууруулж 222,271.8 мянган төгрөгөөр, нийт 948,027.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн дундуур улсын төсвийн санхүүжилтийг 238,150.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 963,906.6 мянган төгрөгийн, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 17,900.2 мянган төгрөгөөр бууруулж 240,172.0 мянган төгрөгөөр, нийт 1,204,078.6 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 963,906.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 240,172.0 мянган төгрөг, нийт 1,204,078.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,084,847.5 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсвийн санхүүжилт 3,822.4 мянган төгрөгийг буцаан татуулж, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс дотуур байрны хүүхдийн ор авахад зориулж 6,300.0 мянган төгрөгийн санхүүжилт олгогдон зарцуулагдаагүй ба 114,107.4 мянган төгрөгийг хэмнэж нийт 120,407.4 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,084,847.5 мянган төгрөг буюу 90.1 хувьтай байгаа нь 6,757.9 мянган төгрөгөөр, дотуур байрны зардал 9,750.0 мянган төгрөгөөр, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал 62,093.0 мянган төгрөгөөр, сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах зардал 33,313.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Хөтөлбөр, арга хэмжээ	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувиар/
Улсын төсвөөс санхүүжих	963,906.6	848,497.9	115,408.7	88.0
80226 - Байр ашиглалтын үйлчилгээ	1,968.9	1,968.9	-	100.0
80312 - Сургалт семинар	984.5	984.4	0.1	100.0
81605 - Эрүүл мэндийг дэмжих	2,374.5	1,485.0	889.5	62.5
81801 - Үдийн цай хөтөлбөр	34,755.4	27,997.5	6,757.9	80.6
81806 - Дотуур байр	95,043.9	85,294.0	9,749.9	89.7
81816 - Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	20,623.6	20,623.6	-	100.0
81823 - Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	4,430.0	4,429.4	0.6	100.0
81827 - Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	1,610.0	322.0	1,288.0	20.0

81834 - Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	608,877.1	546,784.1	62,093.0	89.8
81835 - Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	188,903.2	155,589.4	33,313.8	82.4
81848-Сурах бичгийн түрээс	2,650.4	1,369.5	1,280.9	51.7
83603- Дээд шатны төсвөөс	1,685.1	1,650.1	35.0	97.9
Орон нутгийн төсвөөс санхүүжих	240,172.0	236,349.6	3,822.4	98.4
80111 - Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	240,172.0	236,349.6	3,822.4	98.4
ДҮН	1,204,078.6	1,084,847.5	119,231.1	90.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд хүнсний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтад “Прогресс агро” ХХК оролцож, гүйцэтгэгчээр шалгаран 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Мэдээлэл аудит” ХХК-ийн шинжээч З.Азжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг салбарын захирал А.Гэрэлмаа, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Мэдээлэл аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,017,073.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 15,256.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 28 төрлийн 159 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Мэдээлэл аудит” ХХК-ийн 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 23/47 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,924.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс худалдан авалтыг цахим баримтаар баталгаажуулаагүй зөрчилд 1 албан шаардлага, төсөвт тусгагдаагүй зардал гаргаж илүү цагийн хөлсийг нэмэгдүүлэн олгосон зөрчилд 1 зөвлөмж тус тус өгөгдсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	1	633.70	1	633.70	100.0
Зөвлөмж	1	2,290.80	1	2,290.80	100.0
Нийт дүн	2	2,924.50	2	2,924.50	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн нь 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 2/3151 дүгээр албан бичгээр тус яамны харьяа төсвийн шууд захирагч нарт “2022 оны санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, “Итгэл үзүүлсэн”, “Түүвэрт хамрагдсан” гэж дүгнэгдсэн байгууллагуудын төсөв, санхүүгийн ажилтан нарт батлагдсан төсөвтөө багтаан балансын урамшууллыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг үндэслэн

олгож болно” гэж хууль, эрхийн актад заагдаагүй **балансын урамшуулал** гэгчийг олгохыг зөвшөөрсөн байна.

Уг албан бичгийн дагуу нярав З.Амаржаргалд ажлын үр дүнг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 45.0 хүртэл хувиар тооцон үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал нэг сарын үндсэн цалинтай тэнцэх буюу нийт **868.0** мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:”, 15.1.3 : “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа илрээгүй болно.

Аудитаар нийт **5,053.8** мянган төгрөгийн 6 зөрчил¹ илэрч 2,712.6 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2,341.2 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага, зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй ажилтны цалинтай холбоотой зөрчилд 1 зөвлөмжийг хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд сургалтын менежер Б.Маралчимэгт кабинетын нэмэгдэл хөлсөнд 612.6 мянган төгрөгийг бодож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3-дахь “Ерөнхий боловсролын сургуулийн **багшид** анги даасны 10 хувь, кабинет, лаборатори хариуцан ажилласны 5 хувь, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн заах аргын нэгдлийн ахлагчид заах аргын нэгдэл удирдсаны 5 хувийн нэмэгдэл хөлс тус тус тооцож олгоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэмэгдэл цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

2. Багш С.Одонтуяад төсөв, орон тоонд батлагдаагүй дотоод хяналтын ажил хавсран гүйцэтгүүлж, 2,100.0 мянган төгрөгийн нэмэгдэл цалин бодож олгосон

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үндэслэлгүй олгосон нэмэгдэл цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

5.2 Албан шаардлага:

1. Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс захирал Б.Соёлмаад 745.1 мянган төгрөгийн цалинг илүү бодож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 99.1.“Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Биеэр бүрэн эдлээгүй ээлжийн амралтыг нөхөн эдлүүлж, цалинг суутган тооцох албан шаардлага хүргүүлэх.

2. Хичээлийн жил эхлээгүй байхад буюу 8 дугаар сард хавсралтад дурдсан багш нарт анги даалтын нэмэгдэл 265.7 мянган төгрөгийг бодож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт, Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, Сангийн сайдуудын хамтарсан 2017 оны А/376, А/217/366 дугаар “Журамд өөрчлөлт оруулах тухай” тушаалын 1 дэх “Сурагчийн улирлын амралт болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл, сургалтын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосон боловч багш үндсэн ажлаа гүйцэтгэж байгаа тохиолдолд багшид албан тушаалын үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс урамшил олгоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль журмын дагуу нэмэгдлийг тооцож байх албан шаардлага хүргүүлэх.

3. Бараа, ажил үйлчилгээний зардлаас урсгал засварын зардалд 1,330.4 мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулсан боловч гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтуудыг болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, санхүүгийн тайланг үнэн зөв илэрхийлж байх албан шаардлага хүргүүлэх.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.1. Илрүүлэлт: Сайхан сумын 3 дугаар цэцэрлэгт үндсэн орон тоонд нягтлан бодогчоор ажиллаж буй О.Буяндүүрэнг тус цэцэрлэгт зэрэгцсэн хөдөлмөрөөр нягтлан бодогчоор ажиллуулан, цалинжуулж / үндсэн цалингийн 100.0 хувиар тооцож / байгаа нь дараах хуулиудыг тус тус зөрчиж байна. Үүнд:

- Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх "Төрийн албан хаагч дараах нийтлэг үүрэг хүлээнэ" 37.1.17: "Үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүрэг эрхлэхгүй байх",
- 38 дугаар зүйлийн 38.1 дэх "Төрийн албан хаагч дараах нийтлэг эрх эдэлнэ", 38.1.6: "Багшлах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх", 38.1.7: "Хууль тогтоомжоор хориглоогүй, албан тушаалын ашиг сонирхолд харшлахгүй арга хэлбэрээр хувийн аж ахуй эрхлэх....",
- Хөдөлмөрийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3 дахь "Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээтэй ажилтны нийт ажлын цаг энэ хуулийн 84.4 -т заасан ажлын цагийн дээд хязгаарт багтах ёстой бөгөөд үүнд ажилтан, үндсэн болон зэрэгцсэн ажил олгогч тус тус хяналт тавина", 84 дүгээр зүйлийн 84.4 дэх "Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна" зэрэг.

2.2 Өгсөн зөвлөмж: 2 байгууллагад зэрэгцээ хөдөлмөрөөр нягтлан бодогчийн албан тушаал эрхлүүлж буй зөрчлийг таслан зогсоож, зайлшгүй тохиолдолд 1-ээс илүү зэрэгцээ хөдөлмөр эрхлүүлэхгүй байж, цалинг өдрийн 4 цагаар бодож, 50.0 хувиас хэтрүүлэхгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15 –ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

² Шаллагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сургалтын менежерт кабинетийн нэмэгдэл цалин бодож олгосон	1	612.6	1	612.6								
Төсөвт тусгагдаагүй хавсран ажилласны нэмэгдэл цалин олгосон	1	2,100.0	1	2,100.0								
Улирлын амралттай хугацаанд бус 8 дугаар сард багш нарт анги даалтын нэмэгдэл цалин бодож олгосон	1	265.7			1	265.7						
Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээ эс цалинг илүү бодож олгосон	1	745.1			1	745.1						
Зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан	1	1,330.4			1	1,330.4						
Нягтлан бодогчийг давхар ажил эрхлүүлсэн	1						1					
Дүн	6	5,053.8	2	2,712.6	3	2,341.2	1	-				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Нийт дүн								